

## “АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 03 сарын 31 -ны өдөр

Дугаар 17/01

Улаанбаатар хот

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Соёлын ордонд 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 15:00 цагт эхлэв.

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын агуулгыг танилцуулж, хурлын ирцийн талаарх мэдээг Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөрийг танилцуулна уу гэж индэрт уръя.

### Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөрийг танилцуулснаар:

Тооллогын комиссын шийдвэр:

“Саналын эрхтэй 742,877,000 ширхэг хувьцаа эзэмшигчдийн 696,717,932 ширхэг буюу нийт саналын эрхтэй хувьцааны 93,79% хувийг төлөөлсөн 198 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн” байна. Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

АПУ ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Хурлын даргаар томилогдсон АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг, Санхүү хариуцсан захирал Б.Түвшин, ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ж.Үнэнбат нарыг тайзнаа урилаа.

Хурал даргалагч Ц.Эрдэнэбилэг ээлжит хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

### Хурлын дэг:

1. Хурлын дарга хэлэлцэх асуудлыг танилцуулах
  - I. АПУ ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
  - II. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох;
  - III. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох;

2. Хэлэлцэж байгаа асуудлуутай холбогдсон асуулт, хариулт /хүн тус бүр 3 мин/
3. Тооллогын комисс санал өгөх журмыг тайлбарлах
4. Санал хураалт явуулах
5. Тооллогын комиссоос санал тоолох үйл ажиллагааг явуулах /20 мин/
6. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах
7. Хурлаас гарах шийдвэрийг хурлын дарга танилцуулах /5 мин/
8. Хурлыг хаах

#### **ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

1. АПУ ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;

#### **ТАНИЛЦУУЛСАН НЬ:**

**Хурлын дарга Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг:** АПУ ХК нь 2016 оноос эхлэн 2015 оны үйл ажиллагааны жилийн тайланг ном байдлаар хэвлэж нийтэд мэдээлсэн бөгөөд 2017 онд 2016 оны жилийн тайланг ном байдлаар хэвлэж бэлтгэсэн нь өнөөдөр хувьцаа эзэмшигчид та бүхний гарч байна.

Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав. 2017 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг танилцуулав. Ногдол ашгийн тайланг танилцуулав. (Танилцуулгын агуулгыг товхимол байдлаар хавсарган орууллаа)

**ТҮЗ-ийн Хараат бус гишүүн Ж.Үнэнбат:** Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-ийн дүгнэлтийг танилцуулъя.

1. АПУ ХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд Кэй Пэ Эм Жи хөндлөнгийн Аудитын компани аудит хийж байгаа бөгөөд дүгнэлтээ ТҮЗ-д танилцуулсан. Аудитын дүгнэлт тун удахгүй хэвлэгдэж, жилийн тайлангийн хавсралт болж удахгүй тараагдахаар байгаа болно.
2. АПУ ХК-ийн гүйцэтгэх удирдлага, компанийн хамт олон 2016 онд макро эдийн засгийн таагүй орчноос үүдэлтэй сорилтыг даван туулж, бизнес төлөвлөгөөгөөр тавигдсан зорилго, зорилтуудыг биелүүлэхээр шаргуу ажиллаж, үүргээ хангалттай биелүүлсэн хэмээн дүгнэсэн болно.

**Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг:** Өнгөрсөн оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх танилцуулгатай холбоотой асуулт байвал асууна уу?

#### **Асуулт:**

**Хувьцаа эзэмшигч Дашзвэг:** Ханшийн зөрүүнээс алдагдал гарсныг тайлбарлана уу? Түүний шалтгаан юу вэ? Энэ эрсдэлийг бууруулах ямар арга

хэмжээг төлөвлөж байна вэ? Тухайлбал даатгал хийлгэх зэргээр боломжууд байгааг анхаарч ажиллах хэрэгтэй байна.

**Хариулт:**

**Хурлын дарга Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг:** Вальютын зээлтэй байгаа нөхцөл байдлаас шууд шалтгаалсан алдагдал хүлээж байгаа бөгөөд жилийн 5%-ийн хүйтэй энэ зээлийн нөхцөл одоогийн байдалд хамгийн тохиромжтой байгаа юм. Нөгөө талаас үйлдвэрлэлийн зөв төлөвлөлт нэн чухал бөгөөд вальютын ханшийн эрсдэлээс хамгаалахын тулд бүтээгдэхүүний үнийг өсгөх нөхцөл боломж байгаа боловч бид зах зээлд давамгайлах шинжтэй аж ахуй нэгжээр тогтоогдсон бөгөөд үнээ шууд өсгөх боломж хомс байдаг.

**Асуулт:**

**Хувьцаа эзэмшигч Тунгалаг:** Компанийн жижиг хувьцаа эзэмшигчид хэдэн хувийг эзэлдэг вэ? Ногдол ашгийн хэмжээ бага байна. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр АПУ ХК нь ашгаа АПУ Трейдинг ХХК-д ашгаа шилжүүлж байгаа гэж бичигдэх болсон. Үүнд тайлбар хэлнэ үү. Түүнчлэн ТУЗ-ийн гишүүнд сонгогдох хүмүүсийн нэрс аль хэдийнэ тодорсон санал асуулга өнөөдөр явагдахаар байна. Тэд жижиг хувьцаа эзэмшигчдийг төлөөлөх үү?

**Хариулт:**

**Хурлын дарга Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг:** АПУ Трейдинг ХХК бол АПУ ХК-ийн онцгой эрхт борлуулагч бөгөөд 500 гаруй ажилчидтай, борлуулалт маркетинг, агуулах хадгалалт, тээвэр ложистикийн үйл ажиллагаагаа дангаар эрхэлж бидний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулдаг. Бид 10%-ийн маржин өгдөг, гэвч олон улсын жишигт 20%-ийг өгч борлуулалтаа хариуцуулдаг байх жишээтэй. Үүнд ашгаа шилжүүлж байгаа гэх ямар ч үндэслэл байхгүй юм. Түүнчлэн гадаадын санхүүжүүлэгч байгууллагууд болох Зээлдүүлэгч банкууд (Европын сэргээн босголт хөгжлийн банк, Кредит Свисс)-тай байгуулсан зээлийн гэрээний дагуу байнгын хяналттай байдаг, үйл ажиллагааны тайлагнаж ажилладаг. Нөгөө талаас хөндлөнгийн аудитын компани санхүүгийн тайландауд аудит хийж, аудитын байгууллагын дүгнэлтийг Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж ажилладаг. Одоогоор зохицуулагч байгууллагууд болон зээлдүүлэгч банкуудаас аливаа зөрчил гаргасан гэж тогтоогоогүй бөгөөд бид хуулийн хүрээнд ажиллаж байна.

**ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан:** Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас болон АПУ компанийн веб сайтад томоохон хувьцаа эзэмшигчдийн нэрс, хувь эзэмшлийн хэмжээ зэрэг мэдээллүүд нээлттэй байдаг бөгөөд үүнийг танилцуулбал:

- Туул интернэшнл ХХК - 51,72%
- Wit Alliance limited - 20,09%
- Голомт банк ХХК - 19,9%
- Бусад -8%

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид нь АПУ ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос санал болгосон холбогдох хуулийн шаардлага хангасан хувь хүмүүс бөгөөд Компанийн тухай хуулийн 79-р зүйлд заасан хараат бус гишүүд (манай компанийн хувьд З гишүүн) нь жижиг хувьцаа эзэмшигчдийг төлөөлөх, тэдний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий хүмүүс болно.

**Асуулт:**

**Хувьцаа эзэмшигч Самданпунцаг:** Банк, санхүүгийн байгууллага 1 төгрөгийг тоолдог, гэвч дэлгүүр хоршоо тоолдоггүй. Компанийн хувьцааны 94-97% нь том хувьцаа эзэмшигчдэд байдаг, цөн хувь нь жижиг хувьцаа эзэмшигчдэд ногддог. Хувьцааны үнэ, ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэх боломж байна уу?

**Хариулт:**

**Хурлын дарга Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг:** Зээлийн гэрээний үүргийн дагуу ногдол ашгийн хэмжээг боломжит хувь хэмжээгээр энэ жил хуваарилахаар шийдвэрлэсэн болно. 2019 он хүртэл зээлийн гэрээний үүрэг үргэлжилнэ.

**Асуулт:**

**Хувьцаа эзэмшигч Раднаа:** Би 2 зүйл асууя. 1. Засгийн газрын хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн олон улсын хөтөлбөрөөс онцгой албан татварын хувь хэмжээ нэмэгдэхээр хэвлэл, мэдээллээр ярьж байна. Үүний талаар мэдээлэл та бүхэнд байна уу? 2. АПУ ХК дотоодын зах зээлдээ ханасан болов уу гэж боддог ба экспортын бодлого, үйл ажиллагаа байна уу?

**Хурлын дарга Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг:** 1. Одоогоор албан ёсоор онцгой албан татвар нэмсэн хууль батлагдаагүй байна. Гэвч албан бус мэдээллээр бол 2017 онд нэмэхгүй, 2018 онд 10%, 2019 онд 5%, 2020 онд 5% тус тус онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр байна. 2. Экспорт бол боломж бөгөөд бид хөрөнгө оруулалтыг экспортын үйл ажиллагаандaa нилээдгүй хийдэг. Согтууруулах ундаа бол онцгой бүтээгдэхүүн бөгөөд улс орон бүрийн эрх зүйн зохицуулалт ялгаатайгаас улс бус нутгийн онцлогт уялдуулж ажиллах болдог. Тухайлбал ОХУ-д манай Гранд гэсэн охин компани ажилладаг бөгөөд сибирийн хэсэгт архи импортолдог цор ганц компани байгаа. БНХАУ-ын Өвөр Монголын зах зээл дээр пиво борлуулж байна. Хонконгт “маамуу” брэндийг экспортолж байна. Түүнчлэн МҮ-ын ЗГ, Японы ЗГ хооронд олон улсын хэлэлцээр зурсны дагуу Япон улс руу экспорт хийх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

**Санал:**

**Хувьцаа эзэмшигч Алтан:** Тайлангаас дүгнэхэд компани хүндрэлийн энэ үед боломжийн ажилласан гэж үзэж байна. Вальютын зээлтэй, үйлдвэрлэл борлуулалт буурсан, эдийн засгийн хямралтай байгаа энэ үед ногдол ашиг тарааж өгөхгүй олон олон хувьцаат компани байгаа бөгөөд тодорхой хэмжээнд ногдол ашгийг жил бүр тараадаг компани гэдгийг бид мэднэ. 2017 онд өөдлөх зорилт тавьсан байна. Амжилт хүсье.

**Асуулт:**

**Хувьцаа эзэмшигч Дөлбадрах:** Компани цэвэр ашгийн 10%-ийг ажилчдадаа урамшуулал болгож өгөх боломжтой юу?

**Хариулт:**

**Хурлын дарга Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг:** Гүйцэтгэх удирдлагын зүгээс ТУЗ-д энэ асуудлыг оруулахад таатай байх болно.

**Асуулт:**

**Хувьцаа эзэмшигч Дөлбадрах:** ОХУ-ын сибирь рүү архи, пиво экспортолдог татварын хэмжээ хэд вэ?

**Хариулт:**

**Хурлын дарга Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг:** ОХУ бол харьцангуй тогтвортой хууль тогтоомжтой орон. Согтууруулах ундааны хатуулгаас ялгаатай хувь хэмжээтэй татвар ногддог бөгөөд дундажаар 1 литрт 500 рубль байдаг.

**Асуулт:**

**Хувьцаа эзэмшигч Санжжав:** Зээлийн эргэн төлөлтийн байдлыг танилцуулна уу?

**Хариулт:**

**Хурлын дарга Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг:** 2012-2019 оны хугацаанд нийтдээ 90 сая долларыг гадаадын банкуудаас зээлсэн. Одоогоор 44 сая долларын зээлийг төлөх үлдсэн байна. Үүнээс энэ жилдээ 16 сая долларыг төлөхөөр байгаа бөгөөд зээлийн эргэн төлөлтийг бид хугацаандаа төлөхөөр бизнес төлөвлөгөөндөө тусгаж ажиллаж байна. Дотоодын банкуудаас зээлгүй байна.

**Санал:**

**Хувьцаа эзэмшигч Дашзэвэг:** 2017 онд ТУЗ-ийн дэргэд Ханшийн эрсдэлээс сэргийлэх хороо байгуулах санал гаргаж байх бөгөөд мэргэжлийн зүгээс миний бие та бүхэнтэй хамтран ажиллах саналтай байгааг минь хүлээн авна уу. Экспортыг сайн хийх хэрэгтэй байна. Бага хатуулгатай архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх технологийг нэвтрүүлэх хэрэгтэй. Түүнчлэн реклам, сурталчилгаагаа сайжруулж, Монгол дээд сургуулийн гаднах хананд рекламаа тавиарай. Цэвэр ашгийн 10%-ийг ажилчдадаа өгөхийг ТУЗ дэмжээсэй гэж хүсч байна.

**Хариулт:**

**Хурлын дарга Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг:** Бага хатуулгатай архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх, борлуулах асуудал нийгэмд сөрөг үзэгдэл ихээр дагуулдаг. Тухайлбал БНСУ нэг хүнд ногдох согтууруулах ундааны хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг нь үүнтэй холбоотой байна. Судалгаатайгаар энэ ажлыг хийж байгаа болно.

**Асуулт:**

**Хувьцаа эзэмшигч Боргио:** Ногдол ашиг 1 төгрөг хуваарилсан байна. Уул нь нэгж хувьцаанд 100 төгрөгний ногдол ашиг зарласан бол богино хугацаанд хувьцааны үнэ өсөх арга байсан. Иймд компанийн нэр хүндийг унагасан, 1 төгрөг зарласан одоогийн ТУЗ-ийн гишүүдийг дахин сонгогдох эрхгүй гэж үзэж байна. Түүнчлэн энэ цаг үед компани хөрөнгө оруулалт хийх шаардлага байна уу?

**Хариулт:**

**Хурлын дарга Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг:** Ханшийн хэлбэлзлээс шалтгаалж хөрөнгө оруулалт зогсоодох боломжтой зүйл байгаа.

Нэмэлт асуулт байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох;

**ТАНИЛЦУУЛСАН НЬ:**

**ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан:** Голомт банк ХХК нь компанийн хувьцаа эзэмшигч болсон бөгөөд төлөөллөө ТУЗ-д оруулах санал оруулсан болно. Кумулятив аргаар сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тохиолдолд ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож, дахин сонгох Компанийн тухай хуулийн 77-р зүйлд заасан зохицуулалт үйлчилдэг. Иймд хэлэлцэх асуудал 2-д заагдсан асуудал хуулийн дагуу хэлэлцэгдэж байна.

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн 9 гишүүн (кумулятив аргаар сонгогдох)-ийг сонгох;

**ТАНИЛЦУУЛСАН НЬ:**

**ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан:** АПУ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнд дараах нэр дэвшигчид дэвшиж байна. Үүнд: П.Батсайхан, П.Батчимэг, Б.Батбаяр, С.Громов, Х.Барретт, Х.Хамхоев, Г.Ганболд, П.Батхишиг, И.Майнцэцэг. [Нэр дэвшигчдийн танилцуулгыг товхимолоор хавсаргав]

АПУ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах нэр дэвшигчид дэвшиж байна. Үүнд: С.Эрдэнэ, Ж.Үнэнбат, Б.Батжав, А.Сиваев, Ё.Гэрэлчулуун. [Нэр дэвшигчдийн танилцуулгыг товхимолоор хавсаргав]

Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн дагуу кумулятив аргаар хувьцаат компанийн ТҮЗ-ийн гишүүдийг сонгох журамтай. Кумулятив аргыг хэрэглэх зааврыг танилцуулав. [төвхимол хавсаргав]

Санал хураалт явагдав.

Санал хураалт дуусав.

Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөр: Санал хураалтын дунд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

- “Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах” асуудлаар:

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 695,992,731 ширхэг хувьцаа буюу 99,9%

Татгалзсан - байхгүй

Түдгэлzsэн - нийт саналын эрхтэй хувьцааны 9,110 ширхэг хувьцаа буюу 0,0001%,

Саналын эрхийн 647,558 ширхэг хувьцаатай 37 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

- “АПУ ХК-ийн ТҮЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох” асуудлаар:

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 695,827,212 ширхэг хувьцаа буюу 99,9%,

Татгалзсан - нийт саналын эрхтэй хувьцааны 28,534 ширхэг хувьцаа буюу 0,0004%,

Түдгэлzsэн - нийт саналын эрхтэй хувьцааны 116,220 ширхэг хувьцаа буюу 0,0001%,

Саналын эрхийн 677,793 ширхэг хувьцаатай 40 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

- “АПУ ХК-ийн ТҮЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг кумулятив аргаар сонгох” асуудлаар:

Нэг. Ердийн гишүүд:

№	Нэр дэвшигчид	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1	П.Батсайхан	548,214,845
2	П.Батчимэг	547,679,647
3	Б.Батбаяр	547,660,795

4	С.Б.Громов	547,788,575
5	Х.Ю.Хамхоев	229,062
6	Х.Барретт	547,526,168
7	Г.Ганболд	1,435,080,227
8	П.Батхишиг	336,175
9	И.Майнцэцэг	147,212

Тус тус санал авснаар дараах гишүүд сонгогдов:

№	Нэр дэвшигчид	Хамгийн их санал авсан гишүүд
1	П.Батсайхан	548,214,845
2	П.Батчимэг	547,679,647
3	Б.Батбаяр	547,660,795
4	С.Б.Громов	547,788,575
5	Х.Барретт	547,526,168
6	Г.Ганболд	1,435,080,227

Саналын эрхийн 887,079 ширхэг хувьцаатай 76 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

#### Хоёр. Хараат бус гишүүд:

№	Нэр дэвшигчид	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1	С.Эрдэнэ	148,033,379
2	Ж.Үнэнбат	659,593,411
3	Б.Батжав	547,670,486
4	А.Сиваев	352,030
5	Ё.Гэрэлчулун	695,477,797

Тус тус санал авснаар дараах гишүүд сонгогдов:

№	Нэр дэвшигчид	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1	Ж.Үнэнбат	659,593,411
2	Б.Батжав	547,670,486
3	Ё.Гэрэлчулун	695,477,797

Саналын эрхийн 1,028,487 ширхэг хувьцаатай 48 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

## Хурлын шийдвэр:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилгэг: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. АПУ ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлав.
  2. АПУ ХК-ийн ТҮЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
  3. АПУ ХК-ийн ТҮЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдээс дараах хүмүүсийг сонгов. Үүнд:
    - 1) П.Батсайхан
    - 2) П.Батчимэг
    - 3) Б.Батбаяр
    - 4) С.Б.Громов
    - 5) Х.Барретт
    - 6) Г.Ганболд
  4. АПУ ХК-ийн ТҮЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс дараах хүмүүсийг сонгов. Үүнд:
    - 1) Ж.Үнэнбат
    - 2) Ё.Гэрэлчuluун
    - 3) Б.Батжав

Ээлжит хурлыг хаав.

Хурал 17 цаг 55 минутад дуусав.

ХЯНАСАН

МОНГОЛ УЛС

## Хурлын дарга



Ц.Эрдэнэбүлэг

## ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

## Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга



Ч.Ариунсан